



ХАРИЛЦАА ХОЛБОО, МЭДЭЭЛЛИЙН
ТЕХНОЛОГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2017 оны 06 сарын 22 өдөр

Дугаар 1/65

Улаанбаатар хот

Бодлогын чиглэл батлах тухай

Харилцаа холбооны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.1.3 дахь заалтууд, тус газрын Даргын зөвлөлийн хурлын 2017 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 4 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. “Монгол Улсын харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф, өрсөлдөөний талаар баримтлах бодлогын чиглэл”-ийг хавсралтаар баталсугай.

Хоёр. Дээрх бодлогын чиглэлийн хэрэгжилтийг хангуулан, хяналт тавьж ажиллахыг тус газрын Харилцаа холбоо, шуудангийн бодлого зохицуулалтын хэлтэс /Д.Батбаяр/-т үүрэг болгосугай.

Гурав. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан тус газрын даргын 2012 оны 90 дүгээр тушаалаар баталсан бодлогын чиглэлийг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



Б.ЧИНБАТ

0002125

Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын даргын 2017 оны 06 дүгээр сарын 22-ны өдрийн 0/65 дугаар тушаалын хавсралт



МОНГОЛ УЛСЫН ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТАРИФ, ӨРСӨЛДӨӨНИЙ ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫН ЧИГЛЭЛ

Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Энэхүү баримт бичиг нь Монгол Улсын харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф, өрсөлдөөний талаар баримтлах бодлогын чиглэлийг тодорхойлно.
- 1.2 Харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф, өрсөлдөөний талаарх бодлогын баримтлах чиглэл нь шударга өрсөлдөөнийг дэмжих, хэрэглэгчдэд боломжит үнээр үйлчилгээ хүргэх болон үйлчилгээ эрхлэгчдийн үр ашиг, хөрөнгө оруулалтын өгөөжийг дээшлүүлэх, эдийн засгийн бодит өсөлтийг хангахад чиглэсэн үнэ тариф, өрсөлдөөний бодлого, зохицуулалтын үр ашигтай арга механизмыг бий болгоход оршино.
- 1.3 Дэлхий дахины мэдээлэл харилцаа холбооны технологийн хөгжлийн хандлага, зах зээлийн хөгжлийн хурдацтай уялдуулан энэхүү баримт бичигт тодотгол хийж болно.

Хоёр. Нэр томъёо

Энэхүү баримт бичигт дараах нэр томъёо, тодорхойлолтыг дор дурдсан утгаар хэрэглэнэ. Үүнд:

- 2.1 “тухайн үйлчилгээний зах зээл¹” гэж газар зүйн бүс, хэрэглэгчдийн төрөл, үйлдвэрлэлийн хэмжээ, хугацаа зэрэг нийтлэг шалгуураар тодорхойлогдох, бие биенээ орлож чадах бүтээгдэхүүн үйлчилгээний худалдаа явагдаж буй зах зээлийг;
- 2.2 “жижиглэнгийн үйлчилгээ” гэж үйлчилгээ эрхлэгчээс эцсийн хэрэглэгчид хүргэж буй үйлчилгээг;
- 2.3 “харилцан холболт” гэж үйлчилгээ эрхлэгч өөрийн хэрэглэгчийн бусад үйлчилгээ эрхлэгчийн хэрэглэгчтэй холбогдох хэрэгцээг хангах зорилгоор бусад үйлчилгээ эрхлэгчийн сүлжээтэй шууд болон дамжин холбогдохыг;
- 2.4 “холболт” гэж үйлчилгээ эрхлэгч нь өөрийн үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэх зорилгоор сүлжээ бүхий үйлчилгээ эрхлэгчийн сүлжээнд холбогдохыг;

¹ Relevant market

- 2.5 “дуудсан тал нь төлөх зарчим” гэж дуудлага эхлүүлж буй хэрэглэгч дуудлага төгсгөж буй сүлжээнд төлөх төлбөрийг төлдөг харилцан холболтын төлбөр тооцооны горимыг;
- 2.6 “үндсэн үйлчилгээ” гэж харилцаа холбооны зохицуулах байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлөөр зөвшөөрөгдсөн үйлчилгээг;
- 2.7 “нэгж хэрэглэгчээс олох дундаж орлого²” гэж нийт орлогыг нийт хэрэглэгчдийн тоонд хуваасан хэмжээг;
- 2.8 “өртөгт баримжаалсан” гэж өртөгт суурилсныг хэлэх бөгөөд тэрхүү өртөгт боломжит ашгийг тусгаж болох ба ялгаатай байгууламж болон ялгаатай үйлчилгээний өртгийг харилцан адилгүй аргаар тооцож болно;
- 2.9 “багц³” гэж хоёр болон түүнээс дээш төрлийн бүтээгдхүүний орцтой дундаж хэрэглэгчийн хэрэглээнд тулгуурласан хэрэглэгчийн сар тутмын хэрэглээний хэмжээг тус тус ойлгоно.

Гурав. Харилцаа холбооны үйлчилгээний үнэ тариф, өрсөлдөөний талаар баримтлах зарчим

- 3.1 мэдээлэл, харилцаа холбооны салбарын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг хангахад чиглэх,
- 3.2 мэдээлэл, харилцаа холбооны салбарт үр ашигтай, тогтвортой өрсөлдөх орчныг бий болгох,
- 3.3 төрөөс зах зээл, өрсөлдөөнд нөлөөлөх нөлөөлөл, зохицуулалтыг багасгах,
- 3.4 үйлчилгээ эрхлэгч болон хэрэглэгчийн урт хугацааны үр ашгийг хангах,
- 3.5 зах зээлд шинээр орж ирж байгаа үйлчилгээ эрхлэгчдийн гарааны нөхцлийг бууруулах,
- 3.6 хэрэглэгч боломжит үнээр шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ хүлээн авах боломжийг нэмэгдүүлэх.

Дөрөв. Бодлого, зохицуулалтын байгууллага болон үйлчилгээ эрхлэгчийн үнэ тарифын талаар ажиллах чиглэл

- 4.1 Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага /цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх/ нь дараах үндсэн чиглэлийг мөрдөн ажиллана.
Үүнд:
 - 4.1.1 хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, техник технологийн хөгжлийн чиг хандлагатай нийцсэн үйлчилгээний үнэ тарифын үр ашигтай, уян хатан бодлого баримтлана.

² Average revenue per user (ARPU)

³ Bundle

- 4.1.2 үйлчилгээний үнэ, тарифын бодлогын баримтлах чиглэлийн хэрэгжилт, зах зээл технологийн хөгжлийн өөрчлөлтөд үнэлэлт дүгнэлт өгч, холбогдох асуудлаар судалгаа хийнэ.
 - 4.1.3 харилцаа холбооны зах зээлийн өрсөлдөөн, үйлчилгээний үнэ тарифын зохицуулалтын орчныг сайжруулах талаар Харилцаа холбооны зохицуулах байгууллага /цаашид “Зохицуулах байгууллага” гэх/-д санал, зөвлөмж хүргүүлнэ.
- 4.2 Зохицуулах байгууллага нь хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ дараах үндсэн чиглэлийг баримтална. Үүнд:
- 4.2.1 харилцаа холбооны тухайн үйлчилгээний зах зээлийг тодорхойлох;
 - 4.2.2 харилцаа холбооны тухайн үйлчилгээний зах зээлийн бүтцийг өрсөлдөөний хэлбэрээр нь ангилах;
 - 4.2.3 нэгж хэрэглэгчээс олох дундаж орлогын хэмжээг салбарын ирээдүйн үр өгөөжийг хангахад чиглэсэн байхаар хяналт тавих;
 - 4.2.4 үйлчилгээний үнэ тарифын асуудлаар үйлчилгээ эрхлэгч, хэрэглэгчийн санал, гомдол, хүсэлтийг шийдвэрлэхдээ техникийн болон эдийн засгийн хувьд үр ашигтай байх боломжийг харгалзан үзэх;
 - 4.2.5 зах зээлийн өрсөлдөөний нөхцөл байдлыг судлан эрх бүхий байгууллагыг мэдээллээр хангах;
 - 4.2.6 олон улсын байгууллагаас гаргасан зөвлөмж, техник технологийн чиг хандлагад нийцсэн үнэ тариф тогтоох зөвлөмж аргачлалыг боловсруулах, мөрдүүлэх, хянах.
- 4.3 Үйлчилгээ эрхлэгчид нь үйлчилгээний үнэ тарифыг тогтоохдоо дараах зарчмыг баримтална. Үүнд:
- 4.3.1 энэхүү бодлогын баримт бичигт заасан зарчмуудыг мөрдлөг болгох;
 - 4.3.2 үйлчилгээний үнэ тариф нь ил тод, нээлттэй, үл ялгаварласан, тогтвортой байх;
 - 4.3.3 үйлчилгээний үнэ тариф нь өртөгт баримжаалсан байх;
 - 4.3.4 салбарын ирээдүйн үр өгөөжийг хангахад чиглэсэн байх.

Тав. Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний үнэ тарифын талаар баримтлах чиглэл

- 5.1 Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээний үнэ тариф нь үйлчилгээ эрхлэгчийг давхардуулан дэд бүтэц, сүлжээ барьж байгуулахгүй байх нөхцлийг хангана.
- 5.2 Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ эрхлэгчийн үйлчилгээний нөхцөл болон үнэ тариф нь үл ялгаварласан, ижил тэгш нөхцөлтэй, нийтэд ил тод байна.
- 5.3 Харилцаа холбооны сүлжээний үйлчилгээ эрхлэгчийг улс хоорондын транзит урсгалын үйлчилгээний үнэ тарифаар өрсөлдөхгүй байлгах зохицуулалтын бодлого баримтлана.

Зургаа. Харилцаа холбооны жижиглэнгийн үйлчилгээний үнэ тарифын талаар баримтлах чиглэл

- 6.1 Төгс өрсөлдөөнт зах зээлд жижиглэнгийн үйлчилгээний үнэ, тарифыг үйлчилгээ эрхлэгч өөрөө зах зээлийн зарчмаар тогтоохыг бодлого, зохицуулалтын байгууллагаас дэмжинэ.
- 6.2 Үйлчилгээ эрхлэгч нь үнэ тарифыг тогтоох үйлчилгээний үндсэн хэмжих нэгжийг хөгжлийн чиг хандлага, технологийн нэгдэн нийлэлт, зах зээлийн хувьсал, өөрчлөлттэй уялдуулан, хэрэглэгчдийн эрх ашигт нийцүүлэн тогтооно.
- 6.3 Нэгж хэрэглэгчээс олох дундаж орлогыг ашигт ажиллагааны төвшинтэй уялдуулан тогтвортой байлгах нөхцлийг хангах хэмжээнд үйлчилгээний үнэ тарифыг тогтооно.
- 6.4 Үйлчилгээний үнэ тариф нь стандарт эсвэл багц хэлбэртэй байж болно.
- 6.5 Үйлчилгээ эрхлэгч нь харилцаа холбооны үйлчилгээг багц хэлбэрээр тогтоож болно.
- 6.6 Харилцаа холбооны өөр төрлийн үйлчилгээг багцалсан тохиолдолд нэг төрлийн үйлчилгээний орлогоор нөгөө бүтээгдэхүүн үйлчилгээний алдагдлыг нөхөхгүй байх зарчмыг баримтална.
- 6.7 Интернетийн үйлчилгээний үнэ тарифыг тогтоохдоо хэрэглээнд (volume) суурилах чиглэлийг баримтална.
- 6.8 Улс хоорондын ярианы талаар авч хэрэгжүүлэх бодлого, зохицуулалтын арга хэмжээг зах зээлийг өргөтгөх, экспортын орлогыг нэмэгдүүлэхэд чиглүүлэн хянана.
- 6.9 Роумингийн үйлчилгээний үнэ, тариф нь өртөгт үндэслэх ба үйлчилгээ эрхлэгчид нь үйлчилгээний болон төлбөр тооцооны нөхцлийг хэрэглэгчдэд ил тод мэдээлэхэд зохицуулах байгууллагаас хяналт тавина.

Долоо. Өрсөлдөөн болон зах зээлд нөлөөлөх чадвар бүхий үйлчилгээ эрхлэгчийн үнэ тарифын талаар баримтлах чиглэл

- 7.1 Харилцаа холбооны сүлжээний болон жижиглэнгийн үйлчилгээний зах зээлд шударга өрсөлдөх нөхцөл бүрдүүлэх үүднээс монополь, давамгайлагч, зах зээлд нөлөө үзүүлэх чадвар⁴ бүхий үйлчилгээ эрхлэгчийн өрсөлдөөнд нөлөө үзүүлэх үйлчилгээний үнэ тарифт зохицуулалтын арга хэмжээ авна.
- 7.2 Үнэ тарифын талаар зохицуулалтын арга хэмжээ авах гол зорилго нь зах зээлд нөлөөлөх чадвараа буруугаар ашиглахаас сэргийлэх, үр ашигтай өрсөлдөөнийг идэвхжүүлэх, эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулахад оршино.
- 7.3 Үйлчилгээ эрхлэгч нь өрсөлдөөнд харш үйл ажиллагаа явуулсан, салбарын үр өгөөжид сөргөөр нөлөөлөх нөхцөл үүсгэсэн тохиолдолд зохицуулах байгууллагаас үнэ тарифын зохицуулалтын арга хэрэгслэлүүдийг ашиглан зохицуулалт хийнэ.

⁴ Өрсөлдөөний тухай хуулийн 4.1.10 дахь заалт

Найм. Холболт болон харилцан холболтын үнэ тарифид баримтлах чиглэл

- 8.1 Холболт болон харилцан холболтын зарчим, төлбөрийг зохицуулах байгууллага хянаана.
- 8.2 Харилцан холболтын үйлчилгээ нь сүлжээ бүхий үйлчилгээ эрхлэгчид монополь байдлыг бий болгодог учраас харилцан холболтын төлбөрийг өртөгт баримжаалсан байдлаар тогтоох бөгөөд үйлчилгээ эрхлэгчид нь өртгийн нэгдсэн нэг загвар, аргачлал ашиглана.
- 8.3 Харилцан холболтын төлбөр нь ашиг шингээхгүй бөгөөд бусад үйлчилгээний алдагдлыг нөхөхгүй байх үндсэн зарчмыг баримтална.
- 8.4 Цахилгаан холбооны сүлжээ хоорондын харилцан холболтын үйлчилгээнд дуудсан тал нь төлөх зарчмыг баримтална.
- 8.5 Харилцан холболтын төлбөрийг түүнд оролцож байгаа талуудын жижиглэнгийн үйлчилгээний тарифын байж болох хамгийн доод хязгаар гэж тооцно.
- 8.6 Улс хоорондын яриа төгсгөх харилцан холболтын үнийг дотоод харилцан холболтын үнэтэй тэнцвэржүүлнэ.
- 8.7 Интернетийн дотоод харилцан холболтын үйлчилгээнд арилжааны бус байх зарчмыг баримтална.
- 8.8 Холболтын үнэ тарифыг өртөгт үндэслэн тогтоох ба холболт хийхэд нэмэлт зардал гарахаар бол зардлыг хүсэлт гаргасан тал хариуцна.
- 8.9 Сүлжээ эзэмшигч нь сүлжээнд холбогдох ашиглалт үйлчилгээний зардлыг тооцож, уг зардлыг холбогдсон этгээд хариуцна.
- 8.10 Сүлжээнд холбогдсоноор бий болох орлогын хуваарилалтыг зохицуулах байгуулагаас тогтоож өгөөгүй бол арилжааны зарчмаар талууд шийдвэрлэж болно.

-----oO-----